

Сайн шалга!

Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ!



Хөдөлмөр эрхлэгч ч, ажил олгогч ч
шалгахаа мартуузай. 

Токио хот Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ

2025 оны
10 сарын
3 өдрөөс
Цагийн үнэлгээ

1,226 ^{Өмнөх жилээс UP}
63 иен
иен

モンゴル語版

Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ гэдэг нь хөдөлмөр эрхэлж буй бүх хүнд
цалингийн хамгийн бага үнэлгээг баталгаажуулж буй тогтолцоо юм.

WEB-р шалга!

Хөдөлмөрийн хөлсний
доод хэмжээний талаарх
тусгай вебсайт
(Зөвхөн Япон хэл дээр)



最低賃金 特設サイト

検索

Хөдөлмөрийн хөлсний
доод хэмжээний талаар
лавлах бол Токиогийн
Хөдөлмөрийн товчоо эсвэл
ойролцоох Хөдөлмөрийн стандартын
хяналтын газарт хандана уу.



東京労働局

検索

Хөдөлмөрийн хөлсийг
нэмэгдүүлэх тухай
тусгай хуудас
(Зөвхөн Япон хэл дээр)

Хөдөлмөрийн хөлсийг
нэмэгдүүлэхэд чиглэсэн
дэмжлэгийн бодлогыг нийтэлсэн.



賃金引上げ特設ページ

検索

Жижиг дунд
бизнес эрхлэгч
та бүхэнд



業務改善
助成金

6 сая хүртэл иенийн
дэмжлэг үзүүлнэ





Хөдөлмөр эрхлэгч ч, ажил олгогч ч, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг заавал шалга!

"Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний тогтолцоо" нь нас болон цагийн ажилтан, оюутан зэргээс үл хамааран хөдөлмөр эрхэлж буй бүх хүнд тэгш үйлчилнэ. Шалгахыг хүсэж буй хөдөлмөрийн хөлс ⁽¹⁾ болон ажиллаж байгаа хот, мужийн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ (цагийн үнэлгээ)-г хүснэгтэд бөглөж бичин, харьцуулж үзээрэй! ⁽²⁾

Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг харьцуулах арга

Өөрийн цалин болон харьяа хот, мужийн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний үнэлгээг бичиж үзээрэй. ⁽²⁾

A Цагийн цалинтай хүн

$$\begin{array}{|c|} \hline \text{Цагийн цалин} \\ \hline \text{иен} \\ \hline \end{array} \geq \begin{array}{|c|} \hline \text{Хөдөлмөрийн хөлсний} \\ \text{доод хэмжээ (цагийн үнэлгээ)} \\ \hline \text{иен} \\ \hline \end{array}$$

B Өдрийн цалинтай хүн

$$\begin{array}{|c|} \hline \text{Өдрийн цалин} \\ \hline \text{иен} \\ \hline \end{array} \div \begin{array}{|c|} \hline \text{1 өдрийн} \\ \text{ажлын дундаж цаг} \\ \hline \text{цаг} \\ \hline \end{array} = \begin{array}{|c|} \hline \text{Цагийн үнэлгээ} \\ \hline \text{иен} \\ \hline \end{array} \geq \begin{array}{|c|} \hline \text{Хөдөлмөрийн хөлсний} \\ \text{доод хэмжээ (цагийн үнэлгээ)} \\ \hline \text{иен} \\ \hline \end{array}$$

C Сарын цалинтай хүн

$$\begin{array}{|c|} \hline \text{Сарын цалин} \\ \hline \text{иен} \\ \hline \end{array} \div \begin{array}{|c|} \hline \text{1 сарын} \\ \text{ажлын дундаж цаг} \\ \hline \text{цаг} \\ \hline \end{array} = \begin{array}{|c|} \hline \text{Цагийн үнэлгээ} \\ \hline \text{иен} \\ \hline \end{array} \geq \begin{array}{|c|} \hline \text{Хөдөлмөрийн хөлсний} \\ \text{доод хэмжээ (цагийн үнэлгээ)} \\ \hline \text{иен} \\ \hline \end{array}$$

D Дээрх A, B, C-н холимог хүн

Жишээ нь үндсэн цалин нь өдрийн цалингаар бөгөөд нэмэгдлүүд (Ажлын байрны нэмэгдэл зэрэг) нь сарын цалин байдаг бол

- ① Үндсэн цалин (Өдрийн цалин) → B-ийн тооцоолоор цагийн үнэлгээг бодож гаргана.
- ② Нэмэгдэл хөлс (Сарын цалин) → C-ийн тооцоолоор цагийн үнэлгээг бодож гаргана.
- ③ ① болон ②-ийг нэмсэн дүн ≥ Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ (Цагийн үнэлгээ)

⁽¹⁾ Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй харьцуулахад дараах хөлсийг оролцуулж тооцохгүй.

① Нэмэгдэл хөлс (Гэрлэлтийн нэмэгдэл г.м) ② Нэг сарын хугацаа өнгөрөх тутамд олгох нэмэгдэл хөлс (Урамшуулал г.м) ③ Тогтоосон ажлын цаг хэтэрсэн тохиолдолд олгогдох хөлс (Илүү цагийн нэмэгдэл г.м) ④ Тогтоосон ажлын өдрөөс гадна ажилласан өдрийн олгогдох хөлс (Амралтын өдрийн нэмэгдэл хөлс г.м) ⑤ Оройн 22 цагаас өглөө 5 цаг хүртэлх ажлын цагт олгогдох хөлсөд, өдрийн ажлын цагийн тооцсон үнэлгээнээс илүү гарсан дүн (Шөнийн цагийн нэмэгдэл г.м) ⑥ Ажил таслаж, хоцроогүйн нэмэгдэл, унааны нэмэгдэл болон гэр бүлийн нэмэгдэл

⁽²⁾ Дэлгэрэнгүй тооцоолол хийх арга болон ажил гүйцэтгэлийн цалин олгох үеийн тооцоолох арга зэргийг Хөдөлмөрийн товчоо болон өөрт ойр Хөдөлмөрийн стандарт хяналтын газраас лавлана уу.

業務改善 助成金

6 сая хүртэл иенийн
дэмжлэг үзүүлнэ

Жижиг дунд бизнес эрхлэгч та бүхэнд!

Хөдөлмөрийн хөлсийг нэмэгдүүлэхийг дэмжих
"Бизнесийн үйл ажиллагааг сайжруулах дэмжлэг"-ийг
идэвхтэй ашиглая!



Бизнесийн үйл ажиллагааг сайжруулах дэмжлэг гэдэг нь?

"Бизнесийн үйл ажиллагааг сайжруулах дэмжлэг" нь бүтээмжийг нэмэгдүүлэн "Ажлын байр доторх хамгийн бага хөдөлмөрийн хөлс (ажлын байран дахь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ)"-г нэмэгдүүлэх жижиг дунд аж ахуйн нэгж, бичил бизнес эрхлэгчийг дэмжих тэтгэмж юм. Тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалт зэргийг хийсэн тохиолдолд олгох нөхцөлөөс хамааран тухайн зардлын тодорхой хувийг нөхөн олгоно.

Бизнесийн үйл ажиллагааг сайжруулах
дэмжлэгийн дуудлагын төв

☎ 0120-366-440

Дэлгэрэнгүйг эндээс харна уу.
(Зөвхөн Япон хэл дээр)

業務改善助成金

検索



Олгох нөхцөл



Ажлын байр доторх
хөдөлмөрийн хөлсний
доод хэмжээг нэмэгдүүлэх



Нэмэгдүүлсний дараах
хөдөлмөрийн хөлс
олгох



Үйлдвэрлэлийн
бүтээмжийг сайжруулахад
тусгай тоног төхөөрөмж
зэргийг нэвтрүүлэх



Ажлаас чөлөөлсөн,
хөдөлмөрийн хөлсийг
бууруулсан зэрэг
олголтод үл нийцэх
хүчин зүйл байхгүй.

Тоног төхөөрөмжийн
хөрөнгө оруулалтад
зарцуулсан зардлын
зарим хэсгийг
нөхөн олгох.

Танилцуулгыг
видеогаар
үзэх!



Дэмжлэгийг олгох хүртэлх үйл явц

1



Олгохыг хүссэн өргөдөл, бизнесийн
үйл ажиллагааны төлөвлөгөө зэргийг
ажлын байр нь байгаа орон нутгийн
Хөдөлмөрийн газарт мэдүүлнэ.



Хяналт
шалгалт

2



Олгохоор шийдвэрлэсний дараа
хүргүүлсэн төлөвлөгөөний дагуу
үйл ажиллагаа
явуулах.

3



Хэрэгжүүлсэн үр дүнгийн тайлан,
олгохыг хүссэн өргөдлийг
Хөдөлмөрийн газарт
мэдүүлэх.

4



Хяналт
шалгалт

Цалинг
олгох

Бүрдүүлэлтийг
видеогаар
үзэх!



Мэргэжилтнээс үнэ төлбөргүй зөвлөгөө авах

Хөдөлмөрийн хөлс нэмэгдүүлэлттэй холбоотой ямар нэгэн асуудал байвал
Хөдөлмөрийн нөхцөл байдал сайжруулалтыг дэмжих төвд ирж зөвлөгөө авна уу.

Дэлгэрэнгүйг эндээс харна уу. (Зөвхөн Япон хэл дээр)

働き方改革推進支援センター 検索

Хөдөлмөрийн нөхцөл байдал сайжруулалтын дэмжих сан

Японы Засгийн Газрын Санхүүгийн корпораци нь ажлын байр доторх хөдөлмөрийн хөлсний
доод хэмжээг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээг авч хэрэгжүүлдэг бизнес эрхлэгчид
тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалт, эргэлтийн хөрөнгийн санхүүжилтийг хийдэг.

Дэлгэрэнгүйг эндээс харна уу. (Зөвхөн Япон хэл дээр)

働き方改革推進支援資金 検索

リサイクル適性[®]
この印刷物は、印刷用の紙へ
リサイクルできます。

(R7.9)